



## НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөвлөгөө, ажил үүргийн  
хуваарь батлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг цаг хугацааны хуваарийн дагуу зохион байгуулах Нийслэлийн Сонгуулийн хорооны ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, гишүүдийн ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, жижүүрлэн ажиллах цагийн хуваарийг гуравдугаар, гишүүдийн ажиллах цагийн хуваарийг дөрөвдүгээр, дүүргийн сонгуулийн хороодыг зохион байгуулалт, арга зүйн удирдлагаар хангах хуваарийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг гишүүдэд танилцуулан, баталгаажуулахыг Нарийн бичгийн дарга (Ц.Осорваань)-д, батлагдсан ажил, үүргийн хуваарийг мөрдөж ажиллахыг Нийслэлийн сонгуулийн хорооны нийт гишүүд, ажилтнуудад үүрэг болгосугай.

ДАРГА

П.ХАДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Ц.ОСОРВААНЬ





Нийслэлийн сонгуулийн хорооны  
2024 оны 08 дугаар сарын 07-ны  
өдрийн 07 дүгээр тогтоолын нэгдүгээр  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС АЙМАГ, НИЙСЛЭЛ, СҮМ, ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил, хуулийн заалт	Хуанлийн хугацаа	Хариуцах эзэн
1.	Ажлын төлөвлөгөө гаргах Сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах. (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дахь хэсэг)	2024.08.02-ны өдрөөс өмнө	Ц.Осорваань
2.	Хуулийн хэрэгжилтийг хангуулах Дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах. (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.8 дахь хэсэг)	2024.08.12-ны өдрөөс хойш	Нийт гишүүд
3.	Сонгуулийн хороонд ирсэн хариутай бичиг, өргөдөл, гомдолын шийдвэрлэлтэд хяналт тавих (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.12 дахь хэсэг)	2024.08.02-ны өдрөөс хойш	Нийт гишүүд
4.	Сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах Дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ. (Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь хэсэг)	2024.08.27-ны өдрөөс өмнө	П.Хадбаатар Ц.Осорваань
5.	Хэсгийн хороог байгуулах, хэсгийн хорооны байрны бэлтгэл ажлыг хангах ажиллагаанд хяналт тавих Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ. (Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дахь хэсэг)	2024.08.27-ны өдрөөс өмнө	Нийт гишүүд
6.	Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлж, орон нутгийн сонгуульд оролцох хүсэлтийг хүлээн авах (Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дахь хэсэг)	2024.08.12-ны өдрөөс өмнө	П.Хадбаатар Ц.Осорваань
7.	Нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах (Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг)	Хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор	
8.	Нэр дэвшигчдийн баримт бичгийг хүлээн авах (Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг)	2024.09.05-ны дотор	
9.	Нэр дэвшигчдийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх (Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг)	Хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор	П.Хадбаатар Ц.Осорваань
10.	Саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн эцэг /эх-/ийн нэрийг иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган нягталж, баталгаажуулан үнэн зөвийг хариуцах; (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3 дахь хэсэг)	2024.09.26-ны өдрөөс хойш	П.Хадбаатар Ц.Осорваань (Гишүүд дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)

11.	Нэр дэвшигчийн үнэмлэх олгох, нийтэд мэдээлэх (Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.10 дахь хэсэг)	2024.09.26-ны өдөр	Нийт гишүүд (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)	
12.	Сургалт зохион байгуулах Дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороодын бүрэлдэхүүнд сонгуулийн хууль тогтоомжийн чиглэлээр сургалт зохион байгуулах	2024 оны 09 болон 10 дугаар сард	Ү.Ганболд, бусад гишүүд	
13.	Дүүргийн сонгуулийн хороо болон хэсгийн хороодод хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалт болон архивын баримт бүрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Тухай бүр	Н.Туул болон бусад гишүүд	
14.	Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн	2024.09.16-ны өдрөөс өмнө	Нийт гишүүд
15.	Ухуулах хуудас байрлуулах байршлыг тогтоож, нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавих Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ	(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг)  сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдолын дагуу оруулсан өөрчлөлт; - энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт; - сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт; - нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт; - энэ хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт. (Хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг)	2024.08.12-ны өдрөөс өмнө	М.Халтар, бусад гишүүд

	төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ. (Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг)			
16.	Санал авах өдөр, цаг, байрыг нийтэд мэдээлэх Хэсгийн хороо нь санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. (Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7 дахь хэсэг)	2024.09.27-ны өдрөөс эхлэн санал авах өдрийг дуустал	М.Халтар, бусад гишүүд	
17.	Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн талаарх өргөдөл гомдол, зөрчлийг хянан шалгаж, шийдвэрлэх	Тухай бүрт	Б.Мөнхбаяр (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)	
18.	Нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслагчийн үнэмлэх авах хүсэлтийг тухайн нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш холбогдох сонгуулийн хороо хүлээн авч, Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу олгоно. (Хуулийн 36 дугаар зүйл)	2024.08.17-ны өдрөөс 2024.10.07-ны өдрийг дуустал		
19.	Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах Нэр дэвшигч энэ хуулийн 46.1.1, 46.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ. (Хуулийн 46 дугаар зүйл)	2024.09.29-ний өдрийн дотор	Нийт гишүүд	
20.	Санал авахад шаардлагатай зүйлсийг бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих Тухайн сонгуулийн хэсгийн харьялагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй. (Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг)	2024.10.04-ний өдрөөс өмнө		
21.	Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгөх хүсэлтээ гаргах, хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих	Хуулийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг тодорхойлолтын хамт санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө өөрийн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьялагдах сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэг)	2024.10.04-ний өдрөөс өмнө	Нийт гишүүд
		Сум, дүүргийн сонгуулийн хороо энэ хуулийн 62.4-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт,	2024.10.06-ны өдрөөс өмнө	

		санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө тухайн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсэг)		
		Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадалгааг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө байдлаар хүргүүлнэ (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг)	2024.10.08-ны өдрөөс өмнө	
22.	Ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлэх, бүртгүүлэх ажиллагаанд хяналт тавих	Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ. (Хуулийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэг)	2024.10.06-ны өдрөөс өмнө	
		Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, санал авах өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө ажиглагчийн үнэмлэх олгоно. (Хуулийн 66 дугаар зүйлийн 66.9 дэх хэсэг)	2024.10.09-ний өдрөөс өмнө	
23.	Саналын хуудсыг Санал авах байранд хүргүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлэх ажлыг удирдан зохион байгуулна. (Хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг)		2024.10.08-ны өдрөөс өмнө	
24.	Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах үйл ажиллагаанд хяналт тавих ...сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авна (Хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг)		2024.10.10-ны өдрийн 09:00-20:00 цаг	
25.	Санал авах ажлыг зохион байгуулах Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал	2024.10.11-ний өдрийн	Нийт гишүүд	

	авах өдрийн 07:00 цагаас 20:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. (Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг)	07:00-20:00 цаг	
26.	Төлөөлөгчөөр сонгогдсонд тоосон тухай шийдвэрийг өргөн мэдүүлэх (Хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсэг)	2024.10.18-ны дотор	П.Хадбаатар Ц.Осорваань
27.	Дүүргийн сонгуулийн хороодоос баримт хүлээн авах хуваарийг батлах	2024.10.01-ний өдрийн дотор	Н.Туул болон бусад гишүүд
28.	Дүүргийн сонгуулийн хороодоос баримт хүлээн авах	2024.10.12-2024.10.18	
29.	Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих; (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10 дахь хэсэг)	Тухай бүрт	Б.Төгслхам (Гэрээт нягтлан бодогч)
30.	Дүн мэдээ, баримт бичиг хүргүүлэх Санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу нэгтгэж, хүргүүлэх (Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.13 дахь хэсэг)	Тухай бүрт	Ц.Осорваань Н.Туул
31.	Сонгуулийн хорооны баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах Санал хураалт дууссаны дараа саналын хуудаст агуулагдсан мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангах зорилгоор саналын хуудсыг битүүмжлэх бөгөөд битүүмжлэлийг задлахгүйгээр сонгуулийн бусад бичиг баримтын хамт аймаг, нийслэлийн архивт хадгална. (Хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэг)	Санал авах ажиллагаа дууссаны дараа	
32.	Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг хүргүүлэх Санал хураалтын дүнгийн хуудсыг сонгуулийн бусад бичиг баримтын хамт дүүргүүдийн сонгуулийн хорооноос авч, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн хэсгийн хорооны санал хураалтын дүнг эцэслэн нэгтгэнэ. (Хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.3 дахь хэсэг)		П.Хадбаатар Ц.Осорваань
33.	Төрийн аудитын байгууллагаар хянуулах Нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн тайлан, зардлын зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгүүлэх ажлыг зохион байгуулна. (Хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг)	2024.10.15-ны дотор	Б.Төгслхам (Гэрээт нягтлан бодогч)

## НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО



Нийслэлийн Сонгуулийн хорооны  
2024 оны 28 дугаар сарын 07-ны  
өдрийн 07 дүгээр тогтоолын  
хөөрдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ  
ГИШҮҮД, АЖИЛТНУУДЫН АЖИЛ, ҮҮРГИЙН ХУВААРЬ

№	Гүйцэтгэх үүрэг	Хариуцан ажиллах гишүүн, ажилтны нэр
1.	Нийслэлийн сонгуулийн хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, арга зүйн хувьд нэгдсэн удирдлагаар хангах	
2.	Сонгуулийн хорооны хурлыг товлон зарлах, зохион байгуулж, удирдах	
3.	Сонгуулийн хорооны гишүүдийн хариуцсан ажлын биелэлтэд хяналт тавих	П.Хадбаатар
4.	Нийслэлийн Сонгуулийн хороог төлөөлөх, Сонгуулийн ерөнхий хороо болон төрийн бусад байгууллагатай харилцах	
5.	Дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах	
6.	Сонгуулийн хорооны хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Ц.Осорваань Н.Туул
7.	Сонгуулийн хорооны тэмдэглэлийг хөтөлж, журмын дагуу албажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах	болон гэрээт бичиг хэргийн ажилтан
8.	Нам, эвсэл сонгууль оролцохоо илэрхийлж, ирүүлсэн баримт бичгийн бурдлийг судлах, шийдвэрийн төсөл боловсруулж, Нийслэлийн Сонгуулийн хорооны хуралдаанд танилцуулах	Нийт гишүүд Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу
9.	Нэр дэвшигчдийн ирүүлсэн баримт бичгийн бурдлийг судлах, шийдвэрийн төсөл боловсруулж, Нийслэлийн Сонгуулийн хорооны хуралдаанд танилцуулах	
10.	Сонгуулийн хорооны үйл ажиллагааны талаар болон сонгуулийн хууль тогтоомжийг мэдээллийн самбарт болон цахим хуудсаар сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах, энэ талаар тайлан гаргах	Ү.Ганболд М.Халтар Б.Төгслхам
11.	Сонгуулийн бэлтгэл ажилтай холбоотой баримт материал хэвлүүлэх, тараах, хуваарилах ажлыг зохион байгуулах	
12.	Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой тухайн хорооны бурэн эрхэд хамаарах асуудлаар хяналт шалгалт зохион байгуулах	Г.Галбаяр
13.	Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах зардлыг хуваарилах ажлыг нягтлан бодогчтой хамтран хийх, хорооны хурлаар батлуулах, зарцуулалтад хяналт тавих	Б.Төгслхам болон гэрээт нягтлан бодогч
14.	Дүүргийн сонгуулийн хорооны тэсөв, зарцуулалтад хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	
15.	Саналын хуудасны зарцуулалтын тайлан, мэдээ гаргах	

16.	Мэдээлэл технологийн багийн ажилтнуудыг хариуцан удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах	Нийт гишүүд (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
17.	Сонгуулийн өрөнхий хороо болон бусад байгууллагуудаас ирүүлсэн материал, техник хэрэгсэл, эд хогшлыг хүлээн авч хадгалах, дүүргийн сонгуулийн хороодод хүргүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах	
18.	Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой ажлыг зохион байгуулахад хяналт тавьж ажиллах	
19.	Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, намын ажилтны бүртгэлийг хийж, үнэмлэх олгох, ирүүлсэн бичиг баримтыг цахим хэлбэрээр бүрдүүлж архивлахад бэлэн болгох	Нийт гишүүд (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
20.	Саналын хуудсыг холбогдох сонгуулийн хороодод хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах	
21.	Санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг баталсан маягтын дагуу харьялах сонгуулийн хороодоос гаргуулах, нэгтгэх ажлыг хариуцах	
22.	Хэвлэл мэдээлэлтэй харилцах ажлыг зохион байгуулах	М.Халтар Ү.Ганболд (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
23.	Сонгуулийн хороо, санал авах байранд ажиллах албан хаагчдын сургалтыг зохион байгуулах	Ү.Ганболд (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
24.	Сонгуулийн хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулах	Ц.Осорваань М.Халтар
25.	Нийслэлийн сонгуулийн хороог хууль, шүүхийн байгууллагад төлөөлөх	Б.Мөнхбаяр Р.Цолмонгэрэл (Дүүрэг хариуцсан гишүүд)
26.	Сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх	Нийт гишүүд
27.	Сонгуулийн хороонд ирсэн хариутай албан бичигт хариу хүргүүлэх, асуудлыг боловсруулах, шаардлагатай тохиолдолд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, хариу өгөх	
28.	Дүүргүүдийн сонгуулийн хороодыг зохион байгуулалт, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих	
29.	Баталсан хуваарийн дагуу жижүүрийн үүрэг гүйцэтгэх	Н.Туул Р.Цолмонгэрэл (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
30.	Сонгуулийн хороонд ирсэн хариутай бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих	
31.	Сонгуулийн холбогдолтой тайлан, мэдээг гаргах, хугацаанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах	
32.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан тухай нийслэлийн Сонгуулийн хорооны тайланг нэгтгэн гаргах	Ц.Осорваань Н.Туул

33.	Албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, нийслэлийн Сонгуулийн хорооны бичиг хэргийг хөтлөх, архивлах	Гэрээт бичиг хэргийн ажилтан
34.	Сонгууль дууссаны дараа албан бичиг баримтыг зааврын дагуу эмхэтгэн архивт шилжүүлэх, дүүргийн Сонгуулийн хороодын албан бичгийг архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах	Н.Туул (Дүүрэг хариуцсан хуваарийн дагуу)
35.	Нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэх, сонгуулийн зардлыг санхүүгийн анхан шатны баримтыг тогтоосон журмыг бурдүүлэн зарцуулах	Б.Төгслхам болон гэрээт нягтлан бодогч
36.	Сонгуулийн үйл ажиллагаа дууссаны дараа 7 хоногийн дотор санхүүгийн тайлан гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэх, зардлын гүйцэтгэлд нийслэлийн Аудитын газраар аудит хийлгэх	
37.	Сонгуулийн хорооны гишүүдийн ажиллах нөхцөлийг бурдүүлэх, тэднийг бичиг хэргийн болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах	

### НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО



**НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЖИЖКҮҮР ИЙН ХУВААРЬ**

№	Нэдэл	Түрээ	Мармар	Хамгаалалт	Базар																				
1	М.Хантар																								
2	Ү.Ганболд																								
3	Н.Түүл																								
4	Б.Мөнхбаяр																								
5	Б.Төгсчамх																								
6	Г.Галбаяр																								
7	Р.Цолцонгийнгэрэл																								

Жиш: Батлагдсан цаг хугацааны хуваарь заасан хугацаатай өдрийндейд уртасгасан цагаар ажиллана.

ОРОО НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО



Нийслэлийн Сонгуулийн хорооны  
2024 оны 08 дугаар сарын 22-ны  
өдрийн 00 дугаар 00 тогтолцоо  
деревдүгээр Хавсралт

### НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Огноо	Гариг	Ажиллах цаг	Цайны цаг
1	2024.08.02-ны өдрөөс 2024.10.11-ний өдөр хүртэл	Даваа-Баасан Бямба Ням	ажлын цагаар 10:00-16:00	ажлын цагаар

Жич: Батлагдсан цаг хугацааны хуваарыт заасан хугацаатай өдрийн 00:00 цаг хүртэл ажиллана.

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО



Нийслэлийн Сонгуулийн хорооны  
2024 оны 07 дугаар сарын 07-ны  
өдрийн 07 дүгээр тогтоолын  
тавдугаар хавсралт

Дүүргүүдийн сонгуулийн хороодыг зохион байгуулалт,  
арга зүйн удирдлагаар хангах хуваарь

№	Дүүргийн нэр	Хариуцаж ажиллах гишүүн
1	Баянзүрх дүүрэг	Г.Галбаяр
2	Баянгол дүүрэг	Р.Цолモンгэрэл
3	Сүхбаатар дүүрэг	Н.Туул
4	Чингэлтэй дүүрэг	Б.Төгслхам
5	Сонгинохайрхан дүүрэг	Б.Мөнхбаяр
6	Хан-Уул дүүрэг	М.Халтар
7	Багануур дүүрэг	Ү.Ганболд
8	Багахангай дүүрэг	
9	Налайх дүүрэг	

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО